

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН УРЬДАЧ СУДАЛГАА

Нэгдүгээр хэсэг

2021.02 сар

☎ (976)-7013 7012

✉ contact@mirim.mn

📍 Pro One building, 15th floor, # 1502, Sukhbaatar district,
11th khoroo, Ulaanbaatar-14181, Mongolia

Strategic. Rational. Productive


MIRIM
INNOVATION & CONSULTANT

Marketing
Innovation
Research
Institute of
Mongolia

© 2020 Mirim Consultant LLC.

УДИРТГАЛ


- МИРИМ Консалтант ХХК 2021 оны Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн рейтингийн урьдач судалгааг хийж, судалгааны үр дүнгийн эхний хэсгийг танилцуулж байна.
- Энэхүү судалгааны мэдээллийг 2021 оны 2 сард онлайнаар цуглуулсан.
- Тус судалгааг МИРИМ Консалтант ХХК-ийн санаачилгаар бие даан хийсэн ба судалгаанд илэрхийлэгдсэн агуулга нь түүвэр судалгаагаар авсан олон нийтийн санаа бодлын үр дүн болно.





СУДАЛГААНЫ ЗОРИЛГО:

- ✓ Энэхүү судалгааны зорилго нь улс төрийн нам, лидерүүдийн рейтингийг тодорхойлж, өмнөх сонгуулийн үр дүн, хийж буй ажлыг иргэдээр үнэлүүлэн, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд ямар улс төрчийг нэр дэвшээсэй гэж хүсэж буйг тодруулахад чиглэсэн.



ЗОРИЛТ:

- ✓ Улс төрийн намууд болон гол лидерүүдийн рейтингийн үнэлгээ. Нам болон гол лидерүүдийн рейтингийг тодорхойлж, рейтингд нөлөөлж буй нийгэм, хүн ам зүйн үзүүлэлтийг нарийвчлан харьцуулж гаргах.
- ✓ Өмнөх сонгуулийн үнэлэлт болон гол лидерүүдийн ажлын үнэлгээ. 2017 оны ерөнхийлөгчийн сонгуульд саналаа өгсөн иргэд сонгуулийн үр дүнг хэрхэн үнэлж байгааг судалж, гол лидерүүдийн хийж буй ажлыг иргэдээр үнэлүүлэхэд чиглэнэ.




ХАМРАХ ХҮРЭЭ:

- ✓ Улаанбаатар хот, 20 аймгийн нийтдээ 2549 иргэн оролцсон. Энэ нь Монгол улсын 18-аас дээш насны 2,129,122 иргэнээс ± 2 хувийн алдааны хязгаар дотор 95 хувийн итгэх түвшинтэйгээр төлөөлнө.

$$n = \frac{Z^2 p(1-p)}{C^2}$$

Энд: n-түүврийн хэмжээ, Z-итгэх түвшин (95% -ийн итгэх түвшний хувьд $Z=1.96$), p- сонирхож буй хувьсагчийн илрэх магадлал, C-алдааны хязгаар (итгэх завсар).

ТҮҮВЭР
2549



ЭХ ОЛОНЛОГ, ТҮҮВЭР:

- ✓ Судалгаанд оролцогчдын 49 хувь нь эрэгтэй, 51 хувь нь эмэгтэй байна.
- ✓ Судалгаанд оролцогчдын 16.1 хувь 18-29 хүртэлх насныхан, 19.6 хувь 30-39 насныхан, 20.9 хувь 40-49 насныхан, **29.4 хувь 50-59 насныхан**, 13.6 хувь 60-аас дээш насныхан хамрагдсан.
- ✓ Боловсролын түвшний хувьд **дээд боловсролтой оролцогчид 26 хувь**, тусгай дунд боловсролтой оролцогчид 9.4 хувь, бүрэн дунд боловсролтой оролцогчид 31.6 хувь, бүрэн бус дунд боловсролтой оролцогчид 16.4 хувь, бага болон боловсролгүй оролцогчид 16.6 хувийг эзэлсэн.
- ✓ Ажил эрхлэлтийн хувьд **23.6 хувь төрийн байгууллагад** ажиллагчид, 18.6 хувь хувийн байгууллагад ажилладаг, 16.1 хувь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, **20.2 хувь тэтгэвэр/группт байдаг**, 8.7 хувь тодорхой эрхэлсэн ажилгүй иргэд, 4.4 хувь суралцдаг, 4.4 хувь малчин, тариаланч, 3,9 хувь бусад бүлгээс хамрагдсан.

БОЛОВСРОЛ




График 1. 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд дэмжсэн нэр дэвшигч, хувиар




График 2. 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнгийн үнэлгээ, хувиар



- ✓ Насны бүлгээр харьцуулахад 30-49 насныхан М.Энхболдыг, 50-аас дээш насныхан Х.Баттулга-ыг, 18-29 насныхан С.Ганбаатарыг илүү дэмжсэн хандлага ажиглагдаж байна.
- ✓ Ажил эрхлэлтээр харьцуулахад тэтгэвэр/группт байдаг иргэд М.Энхболдыг, төрийн болон хувийн байгууллагад ажилладаг, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, тэтгэвэр/группт байдаг, эрхэлсэн ажилгүй иргэд Х.Баттулгыг, бусад бүлгийн иргэд С.Ганбаатарыг түлхүү дэмжжээ.
- ✓ Боловсролын хувьд дээд боловсролтой иргэд М.Энхболдыг, бүрэн дундаас доош боловсролтой иргэд С.Ганбаатарыг, тусгай дунд боловсролтой иргэд Х.Баттулгыг илүү дэмжсэн байна.
- ✓ Судалгаанд оролцогчдыг 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнг хэрхэн үнэлж байгааг тодруулахад 57 хувь миний сонголт зөв байсан, 30 хувь ялгаагүй байсан, 14 хувь тэр үед буруу сонголт хийсэн гэжээ.

✓ 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн төлөө саналаа өгсөн үр дүнг үнэлгээтэй харьцуулахад Х.Баттулгад саналаа өгсөн иргэдийн 72 хувь миний сонголт зөв байсан хэмээн хариулсан бол,

✓ М.Энхболд, С.Ганбаатар нарт саналаа өгсөн иргэдийн 47-48 хувь миний сонголт зөв байсан,

✓ 33-44 хувь ялгаагүй байсан гэсэн хариултыг өгсөн. Харин сонгуульд оролцоогүй иргэдийн 66 хувь ялгаагүй байсан гэсэн сонголтыг хийсэн.

График 3. 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн төлөө саналаа өгсөн хувийг үнэлгээгээр харьцуулсан үзүүлэлт, хувиар





График 4. Ерөнхийлөгч Х.Баттулга, Ерөнхий сайд асан У.Хүрэлсүхийн хийж буй ажлыг үнэлж буй байдал, хувиар



- ✓ Ерөнхийлөгч Х.Баттулгын хийж буй ажлыг 39 хүртэлх насны залуучууд, 50-аас дээш насныхан хүлээн зөвшөөрөх, 40-49 насныхан эсэргүүцэх хандлагатай байгаа бол, Ерөнхий сайд асан У.Хүрэлсүхийн хийж буй ажлыг 30-49 насныхан хүлээн зөвшөөрөх, 18-29 болон 50-аас дээш насныхан эсэргүүцэх хандлага илүү байна.
- ✓ Ерөнхийлөгч Х.Баттулгын хийж буй ажлыг эсэргүүцэж буй иргэдийн хувь (29%), Ерөнхий сайд асан У.Хүрэлсүхийн хийж буй ажлыг эсэргүүцэж буй иргэдээс 4 хувиар бага байна.
- ✓ Ерөнхийлөгч Х.Баттулгын хийж буй ажлыг эмэгтэйчүүд, У.Хүрэлсүхийн хийж буй ажлыг эрэгтэйчүүд хүлээн зөвшөөрөх хандлага давамгайлж байна.
- ✓ Ажил эрхлэлтээр харьцуулахад Х.Баттулгын хийж буй ажлыг хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэд хүлээн зөвшөөрөх, төрийн болон хувийн байгууллагад ажилладаг иргэд эсэргүүцэх хандлага давамгайлж байгаа бол, У.Хүрэлсүхийн хийж буй ажлыг тэтгэвэр/группт байдаг иргэд хүлээн зөвшөөрөх, бусад бүлгийн иргэд эсэргүүцэх хандлагатай байна.

График 5. Иргэдийн 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох оролцоо, хувиар



1. Судалгаанд оролцогчид 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд 45 хувь тулхтай туршлагатай улс төрчдийг, 33 хувь туршлагатай, төлөвшсөн улс төрийн хүчнийг дэмжиж, сонгохоо илэрхийлжээ.
2. Насаар нь харьцуулахад 18-29 насныхан шинэ залуу боловсон хүчнийг дэмжиж улс төрд салхи оруулахыг, 30-59 насныхан туршлагатай, төлөвшсөн улс төрийн хүчин, тулхтай улс төрчдийг сонгох хандлага илүү байна.
3. Хүйсийн хувьд эрэгтэйчүүд тулхтай, туршлагатай улс төрчдийг, эмэгтэйчүүд туршлагатай, төлөвшсөн улс төрийн хүчнийг дэмжинэ гэж хариулсан хувь илүү байна.
4. Боловсролын түвшнөөр харьцуулахад дээд болон бүрэн дунд боловсролтой иргэд туршлагатай, төлөвшсөн улс төрийн хүчнийг, дээд, бүрэн дунд болон бүрэн бус боловсролтой иргэд тулхтай туршлагатай улс төрчдийг дэмжих хандлага ажиглагдаж байна.

Дараагийн хэсэгт доорх агуулгыг нийтлэх болно.

- Улс төрийн намын рейтинг
- Сонгогчдын саналын шилжилт
- Намын лидерүүдийн рейтинг